



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/24

Эг

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, Ахмад настны тухай хуулийн 12.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний өдрийг тохиолдуулан 80-90 хүртэлх насны 29 ахмадад хавсралтад заасны дагуу тус бүр 50,000 (тавин мянган) төгрөг, нийт 1,450,000 (нэг сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардуулсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Б.Цолмон)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАЛТАНГЭРЭЛ

23250104